



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/30

Амардалай

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан, хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тооцон гаргахыг Засаг даргын орлогч /Л.Золжаргал/, ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/ нарт үүрэг болгосугай.

Гурав: Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төлөвлөгөөний холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, байнгын хяналт тавих, төрийн байгууллагаас авилгын эсрэг явуулж буй үйл ажиллагааг дүгнэх аргачлалын дагуу дүгнэж, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж тайлагнахыг ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ



4880100089

